



МИНШЭЭЛ-ОД АУДИТ ХХК

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

МОНГОЛ САВХИ ХК-ИЙН 2024 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТ

Аудитын код: МОА-2024/А-08/СТА-ХК

2025 он

"Монгол савхи" ХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн тайлангийн аудит



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Монгол савхи ХК-ийн 2024 оны санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: MOA-2024/A-08/ СТА-ХХК

Цахим хуудас:

www.misheelodaudit.mn

Улаанбаатар хот

2025 он

Тэргүүлэх аудитор: Т.Одончимэг

Утас: 99069029 Цахим хаяг: info@misheelodaudit.mn

Аудитын менежер: Э.Энхцэцэг

Утас: 99065204 Цахим хаяг: enkhitsatseg@misheelodaudit.mn

Аудитор: М.Цэнд-Аюуш

Утас: 99239991 Цахим хаяг: misheelod@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
МОА	Мишээл-Од Аудит ХХК
СТА	Санхүүгийн тайлангийн аудит

1. Агуулга

КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ.....	3
1. Аудитын гэрчилгээ.....	4-6
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	7-12
2.1. Санхүүгийн байдлын тайлан	
2.2. Орлогын дэлгэрэнгүй тайлан	
2.3. Өмчийн өөрчлөлтийн тайлан	
2.4. Мөнгөн гүйлгээний тайлан	
3. Аудитын тайлан.....	13-15
3.1. Ерөнхий зүйл	
3.2. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	
3.3. Санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	
3.4. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	
3.5. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	
3.6. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль эрх зүйн орчин	
3.7. Нягтлан бодох бүртгэлийн бодлого	
3.8. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	
4. Завсрын аудитын илрүүлэлт, өмнөх аудитын зөвлөмжийн хэрэгжилт	
4.1. Аудитын явцад залруулсан алдаа	
4.2. Аудитын зөвлөмж	
5. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	15-24

КОМПАНИЙН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ: "МОНГОЛ САВХИ" ХХК

Үүсгэн байгуулах шийдвэр:	Монгол савхи" ХК нь 1996 оны 04-р сарын 26-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр батлагдсан Компанийн дүрмийн дагуу үүсгэн байгуулагдсан.
Гэрчилгээ:	2008 оны 01-р сарын 23-ний өдөр Монгол улсын Улсын Бүртгэлийн Ерөнхий Газарт бүртгүүлж, улсын бүртгэлийн 2075148 регистрийн дугаар бүхий 9010001065 тоот улсын бүртгэлийн гэрчилгээ авсан.
Үндсэн үйл Ажиллагаа:	Компанийн үндсэн үйл ажиллагаа нь савхи болон арьс ширний эдлэлийн үйлдвэрлэл, барааны дэлгүүр, үл хөдлөх хөрөнгийн түрээс
Хувьцаа эзэмшигч:	МУ-ын 9175 иргэн эзэмшиж байна. Дүрмийн сан нь 2,475,343 мянган төгрөг байна.
Гүйцэтгэх захирал: Ерөнхий нягтлан бодогч:	Д.Хуушаан Утас: 91915571 Ч.Тогтохбаяр Утас: 99097605
Компанийн хаяг:	МОНГОЛ САВХИ ХХК Хан-Уул дүүрэг, 2-р хороо, Чингисийн өргөн чөлөө өөрийн байр, Улаанбаатар хот, Монгол улс Утас: (+976-342736) И-мэйл:
Аудитын компанийн хаяг:	"МИШЭЭЛ- ОД АУДИТ" ХХК ЭРХИ төв 703 тоот, Сөүлийн гудамж, Баянгол дүүрэг 2-р хороо, Улаанбаатар хот, Монгол улс Утас: (+976-7016-9029) (+976 -9906-9029) (+976 -9906-5204) И-мэйл: info@misheelodaudit.mn

1. Аудитын санал дүгнэлт



МОНГОЛ САВХИ ХК-ИЙН ЗАХИРАЛ
Д.ХУУШААН танаа

МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК

Нягтлан бодох бүртгэл, Аудит, Баталгаажуулалт, Аудиторын үйлчилгээ, Бизнесийн зөвлөгөө өгөх

2025.02.25 № 25/A09

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Зөрчилгүй санал дүгнэлт

Бид 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн Монгол савхи ХК-ийн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний үзэж байгаагаар эдгээр санхүүгийн тайлангууд нь бүхий л материаллаг асуудлаар Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, үнэн зөв илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт /АОУС/-уудын дагуу хийсэн. Эдгээр стандартын дагуу хүлээх хариуцлагаа энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт тайлбарласан. Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөл (НБЕЗОУСЗ)-өөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Аудитын тухай Монгол улсын хуулиар санхүүгийн тайлангийн аудитад тавигддаг ёс зүйн шаардлагын дагуу Бид байгууллагаас хараат бус бөгөөд хууль болон НБЕЗОУСЗ-өөс гаргасан дүрмийн шаардлагын дагуу тавигддаг ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн.

Аудитаар Монгол савхи ХК-ийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Асуудлыг онцолсон зүйл

Удирдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхий Этгээдүүдийн Санхүүгийн Тайланд хүлээх Үүрэг Хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдаанаас үүсэх материаллаг алдаатай илэрхийлэлгүй бэлтгэхэд зайлшгүй чухал гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага Компанийн үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудаа гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Санхүүгийн Тайлангийн Аудитад хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага

Бидний үүрэг хариуцлага бол гүйцэтгэсэн аудитдаа тулгуурлан эдгээр санхүүгийн тайлангуудад дүгнэлт гаргах явдал юм. Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэдэг. Эдгээр стандартууд нь ёс зүйн шаардлагуудыг баримталж, санхүүгийн тайлангууд нь материаллаг зөрчилгүй илэрхийлэгдсэн эсэх талаар ул үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг биднээс шаарддаг.

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ анги эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм.

Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай материаллагт тооцогддог.

Санхүүгийн тайлагналыг бүхэлд нь үнэлэхээс гадна, удирдлагын зүгээс хийсэн томоохон тооцооллуудын үндэслэлтэй байдал, хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын тохиромжтой байдлыг үнэлэх ажлыг бидний аудит багтаасан.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

Бидний гүйцэтгэсэн аудит нь аудитын дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоогоор хангагдсан гэж бид итгэж байна.

Бусад асуудал

Энэхүү аудиторын дүгнэлт нь зөвхөн Монгол савхи ХХК-ийн хувьцаа эзэмшигчдэд зориулагдсан бөгөөд бусад этгээд ашиглах ёсгүй. Энэхүү тайлангийн хүрээнд бид гуравдагч этгээдийн өмнө хариуцлага хүлээхгүй.

Хүндэтгэсэн:

МИШЭЭЛ ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Мэргэшсэн нягтлан бодогчид



2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	186,180.61	756,445.43
1.1.2	Дансны авлага	240,403,801.95	276,471,197.01
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага		
1.1.4	Бусад авлага		
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бариа материал		
1.1.7	Урьдчилж төлсөн зардал		
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	1,885,292.71	1,885,292.71
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
1.1.10			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	242,476,276.27	279,112,935.15
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,484,229,172.44	1,450,522,693.23
1.2.2	Биет бус хөрөнгө		
1.2.3	Мал амьтад		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	70,376,454.00	70,376,454.00
1.2.5	Хайгуул үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө		
1.2.7	Хөрөнгө оруулалт ба бусад хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.9			
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,554,605,626.44	1,520,899,147.23
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,797,080,901.71	1,800,012,082.38
2	Өр төлбөр ба эзэмшигчийн өмч		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	450,850,249.81	452,200,249.81
2.1.1.2	Цалингийн өглөг	1,926,490.00	509,333.00
2.1.1.3	Татварын өр	24,121,631.06	7,259,724.47
2.1.1.4	ЭМНД-ийн шимтгэлийн өглөг		
2.1.1.5	Банкны богино хугацаат зээл		

"Монгол савхи" ХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн тайлангийн аудит

2.1.1.6	Хүүний өглөг		
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого		
2.1.1.9	Нөөц /ер төлбөр/		
2.1.1.10	Бусад богино хугацаат ер төлбөр		
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-нд хамаарах ер төлбөр		
2.1.1.12			
	Богино хугацаат ер төлбөрийн дүн	476,898,370.87	459,969,307.28
2.1.2	Урт хугацаат ер төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл		-
2.1.2.2	Нөөц /ер төлбөр/		-
2.1.2.3	Хойшлогдсон татварын ер	-	-
2.1.2.4	Бусад урт хугацаат ер төлбөр	-	-
2.1.2.5			
	Урт хугацаат ер төлбөрийн дүн	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	476,898,370.87	459,969,307.28
2.3	Эзэмшигчдийн өмч		
2.3.1	Өмч: а) төрийн	-	-
2.3.2	б) хувийн		
2.3.3	Хувьцаат капиталын дүн	247,534,300.00	247,534,300.00
2.3.4	Халаасны хувьцаа	(8,949,028.48)	(8,949,028.48)
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Дахин үнэлгээний нөөц	1,486,241,141.00	1,486,241,141.00
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг		
2.3.9	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	-404,643,881.68	-384,783,637.42
2.3.10			
2.3.11	Эзэмшигчдийн өмчийн дүн	1,320,182,530.84	1,340,042,775.10
2.4	Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн	1,797,080,901.71	1,800,012,082.38

2.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого		
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг		
3	Нийт ашиг (алдагдал)	-	-
4	Түрээсийн орлого	215,230,596.33	412,233,590.88
5	Хүүгийн орлого		
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого		
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	299,524,287.83	387,778,419.54
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал	5,388,662.00	2,189,833.45
13	Валютын ханшийн өөрчлөлтөөс үүссэн ашиг (алдагдал)		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		40,423.50
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(89,682,353.50)	22,305,761.39
19	Орлогын татварын зардал		2,445,517.13
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(89,682,353.50)	19,860,244.26
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(89,682,353.50)	19,860,244.26
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн	(89,682,353.50)	19,860,244.26
25	Нэгж хувьцаат ноогдох ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Халаасны хувьцаа	Дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	247,534,300.00	(8,949,028.48)	1,486,241,141.00	-314,961,528.18	1,409,864,884.34
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					-
Залруулсан үлдэгдэл	247,534,300.00	(8,949,028.48)	1,486,241,141.00	(314,961,528.18)	1,409,864,884.34
Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)				(89,682,353.50)	(89,682,353.50)
Бусад дэлгэрэнгүй орлого					-
Өмчид гарсан өөрчлөлт					-
Зарласан ногдол ашиг					-
Дахин үнэлгээний нэмэгдэл					-
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	247,534,300.00	(8,949,028.48)	1,486,241,141.00	(404,643,881.68)	1,320,182,530.84
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					-
Залруулсан үлдэгдэл	247,534,300.00	(8,949,028.48)	1,486,241,141.00	(404,643,881.68)	1,320,182,530.84
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				19,860,244.26	19,860,244.26
Бусад дэлгэрэнгүй орлого					-
Өмчид гарсан өөрчлөлт					-
Зарласан ногдол ашиг					-
Дахин үнэлгээний нэмэгдэл					-
2024 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	247,534,300.00	(8,949,028.48)	1,486,241,141.00	(384,783,637.42)	1,340,042,775.10

2.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөгөөр/

1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	Өмнөх он	Тайлант он
1.1	Мөнгөн орлогын дүн	236,753,656.00	453,866,950.00
1.1.1	Борлуулалтын болон худалдан авагчдаас орсон мөнгө	236,753,656.00	453,456,950.00
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	
1.1.4	Буцаан авсан албан татвар		
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого		
1.1.6	Бусад орлого	-	410,000.00
1.2	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага	290,761,879.36	450,409,139.73
1.2.1	Ажиллагчдад олгосон мөнгө	80,859,387.00	123,205,690.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	21,827,631.52	22,604,119.31
1.2.3	Түүхий эд материал худалдан авахад төлсөн мөнгө		
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	97,120,871.29	137,428,360.46
1.2.5	Түлш шатахуун тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	757,834.55	635,727.28
1.2.6	Төлсөн хүү		
1.2.7	Төлсөн орлогын татвар	57,424,194.76	114,894,747.61
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн мөнгө		
1.2.9	Бусад зардал	32,771,960.24	51,640,495.07
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(54,008,223.36)	3,457,810.27
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн	-	-
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого		-
2.1.7	Хүлээн авсан хүү, ногдол ашиг		
2.2	Мөнгөн зарлагын дүн	19,359,763.64	4,237,545.45

"Монгол савхи" ХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн
тайлангийн аудит

2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	19,359,763.64	4,237,545.45
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(19,359,763.64)	(4,237,545.45)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн	73,540,000.00	1,350,000.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	73,540,000.00	1,350,000.00
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.1.3	Төрөл бүрийн хандив		
3.2	Мөнгөн зарлагын дүн	240,000.00	240,000.00
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	240,000.00	240,000.00
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
3.2.4	Төлсөн ногдол ашиг	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	73,300,000.00	1,350,000.00
4	Валютын ханшийн зөрүү		
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(67,987.00)	570,264.82
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	254,167.61	186,180.61
7	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	186,180.61	756,445.43

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Бид Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, Аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 10 дугаар зүйлийн 10.1.1-д заасны дагуу Монгол савхи ХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийж, санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Захирал Д.Хуушаан танд танилцуулж байна.

Аудитын тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2025 оны 02 дүгээр сарын 11-нээс 2025 оны 02 дүгээр сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2025 оны 02 дүгээр сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Мишээл-Од Аудит ХХК-ийн захирал, аудитын багийн ахлагч Т.Одончимэг, ахлах аудитор М.Цэнд-Аюуш чанарын хяналтын менежер Э.Энхцэцэг, аудиторын туслах Э.Ундрах-Эрдэнэ, Т.Алтанчимэг нар хариуцаж хэрэгжүүлэв.

Монгол савхи ХК-ийн 2024 оны санхүүгийн тайланг Мишээл-Од Аудит ХХК-д 2025 оны 02 сарын 04-ний өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Мишээл-Од Аудит ХХК-ийн санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчим, арга зүйд нийцүүлэн аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу санхүүгийн тайланд аудитыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно. Аудитыг дээрх бодлого, явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, СТОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

3.3. Санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Монгол савхи ХК-ийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Монгол савхи ХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзсэн ба дараагийн аудитад дотоод хяналтын ажилтнуудтай холбоотой ажиллах бодолтой байна.

3.4. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Монгол савхи ХК-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 11 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 12 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

3.5. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайланг сонгож, 2024 оны нийт орлого 412,274,074.38 төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 8,245,481.00 төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

3.6. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Монгол савхи ХК нь 2008 онд үүсэн байгуулагдаж савхи болон арьс ширний эдлэлийн үйлдвэрлэл, барааны дэлгүүр, үл хөдлөх хөрөнгийн түрээс чиглэлээр үйл ажиллагаагаа эхлүүлсэн байна.

2024 оны 12 сарын 31-ний байдлаар хүчин төгөлдөр" Компани"-ийн дүрмийн дагуу хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүн болон хувьцаат капитал нь дараах байдалтай байна.

Хувьцаа эзэмшигчийн нэр	Эзэмшлийн хувь	2024 оны 12 сарын 31-ний байдлаар		
		Тоо хэмжээ	Нэгж үнэ /Төгрөг/	Нийт үнэ /мянган төгрөг/
Хувьцаа эзэмшигч 9175 хүн	100%	2,475,343	100	247,534,300.00
Хөрөнгийн дүн		2,475,343		247,534,300.00

Тайлант онд 412,274,014.38 төгрөгийн орлого, 392,413,770.12 төгрөгийн зардал гаргаж 19,860,244.30 төгрөгийн ашигтай ажилласнаар орлогын дэлгэрэнгүй тайланд тайлагнасан байна.

3.7. Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн: 4.1.1-д Аж ахуйн нэгж байгууллага нь "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартыг мөрдөнө" гэж заасан нь компани санхүүгийн үйл ажиллагаагаа хөтлөхдөө Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж мөрдөх хууль зүйн үндэслэл болно..

5. Санхүүгийн тайлангийн тодруулга

5.1. Санхүүгийн тайланг бэлтгэсэн тухай

Энэхүү санхүүгийн тайланг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (цаашид СТОУС гэх), Монгол Улсын зохих хууль, тогтоомжийн дагуу бэлтгэсэн.

Компанийн нягтлан бодох бүртгэл болон санхүүгийн тайланг Монгол Улсын үндэсний валют төгрөгөөр бэлтгэсэн. Эдгээр санхүүгийн тайлангууд нь төгрөгөөр илэрхийлэгдэж тодруулга дахь илэрхийллийг мянган төгрөгөөр нарийвчлан харуулж тайлагнагдсан.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6.1, НББОУС-1-27-д "Аж ахуйн нэгж нь мөнгөн гүйлгээний мэдээллээс бусад санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурь дээр үндэслэн бэлтгэх ёстой" гэж заасны дагуу Компани нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурьд үндэслэн санхүүгийн тайлангаа бэлтгэдэг.

Энэ арга орлого, зардал болон хөрөнгө, өр төлбөрийн хоорондын уялдааг сайжруулж өгдөг ба мэдээлэл хэрэглэгчдийн хувьд санхүүгийн мэдээлэл бодит байдалд илүү ойр бэлтгэгдсэн байдаг.

Санхүүгийн тайланг бэлтгэх төсөөлөл:

НББОУС 1-25-д Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага нь үйл ажиллагаагаа тасралтгүй байдлаар үргэлжлүүлэн явуулах чадвар боломжийг үнэлнэ. Удирдлага нь аж ахуйн нэгжийг татан буулгах буюу түүний үйл ажиллагааг зогсоохоор төлөвлөж байгаа эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүйгээс бусад тохиолдолд санхүүгийн тайланг тасралтгүй байх зарчмын дагуу бэлтгэх ёстой.

Тус компани үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлнэ гэсэн төсөөлөлд үндэслэн санхүүгийн тайлангаа бэлтгэсэн байна.

5.2. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд

Санхүүгийн тайлан гэдэг нь нягтлан бодох бүртгэлийн мэдээний цуглуулалт, ангилан зохион байгуулалт ба эцсийн нэгтгэл товчоог харуулсан тайлан буюу нэгдлийн санхүүгийн байдал ба санхүүгийн гүйцэтгэлийн бүтэцчилсэн толилуулгыг хэлнэ.

НББОУС-1-9-д Санхүүгийн тайлан нь аж ахуйн нэгжийн санхүүгийн байдал ба санхүүгийн үр дүнгийн бүтэцчилсэн илэрхийлэл юм. Санхүүгийн тайлангийн зорилго янз бүрийн хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэр гаргахад ач холбогдолтой тухайн аж ахуйн нэгжийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээний талаарх мэдээллээр хангах явдал юм. Мөн санхүүгийн тайлан нь удирдлагад хариуцуулан өгсөн хөрөнгийн талаарх түүний хариуцлагын үр дүнг харуулдаг. Энэхүү зорилгыг хангахын тулд санхүүгийн тайлан нь аж ахуйн нэгжийн дараах зүйлсийн талаарх мэдээллээр хангадаг.

- (a) Хөрөнгө;
- (b) Өр төлбөр;
- (c) Өмч;
- (d) Орлого, зардал үүнд олз ба гарз хамаарна;
- (e) Эзэд болохын хувьд тэдний бүхэн эрхийн хүрээнд эздээс оруулсан хувь оролцоо ба эздэд олгосон хуваарилалт; ба
- (f) Мөнгөн гүйлгээ.

Компани эдгээр шаардлагуудыг хангасан санхүүгийн тайланг бэлтгэж бидэнд ирүүлсэн байна.

Мөнгө, түүнтэй адилтгах орлого:

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгөд нь бэлэн мөнгө болон банкин дах харилцах дансдуудыг тайлагнасан.

НББОУС-7-6-д мөнгийг дараах байдлаар тодорхойлсон байна:

Мөнгө нь бэлэн мөнгө ба харилцах данснаас бүрдэнэ.

Мөнгөтэй адилтгах хөрөнгө - үнэ цэний өөрчлөлтийн маш бага эрсдэлтэй, мөнгөний тодорхой дүнд чөлөөтэй хөрвөх боломжтой богино хугацаат, ихээхэн өндөр хөрвөх чадвартай хөрөнгө оруулалт юм.

2024 оны 12 сарын 31-ны байдлаар компанийн харилцах данснууд нь дараах байдалтай байршиж 756,445.43 төгрөгийн үлдэгдэлтэй байна. / төгрөг/

№	Мөнгөн хөрөнгийн зүйлс	Мөнгө байршиж байгаа банк	Валютын төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Касс дахь мөнгө		Төгрөг	101,996.48	233,585.48
2	Банкин дахь мөнгө	ХХБанк	Төгрөг		
		Капитрон банк	Төгрөг	84,184.48	522,859.95
3	Хадгаламж				
4	Мөнгөтэй адилтгах хөрөнгө				
	Нийт дүн			186,180.96	756,445.43

Үндэсний валютын нэрлэсэн үнээр, гадаад валютаар гарсан мөнгөн хөрөнгийг Монгол банкнаас зарласан албан ханшаар төгрөгт хөрвүүлж бүртгэдэг. Гадаад валютаар хийгдсэн ажил гүйлгээг ажил гүйлгээ гарсан өдрийн Монгол банкнаас зарласан албан ханшаар төгрөгт шилжүүлж бүртгэдэг.

Тайлант үе бүрийн эцэст:

- гадаад валютаар илэрхийлсэн мөнгөн зүйлсийг Монгол банкны хаалтын ханшаар тайлагнана
- гадаад валютаарх түүхэн өртгөөрөө хэмжигдсэн мөнгөн бус зүйлсийг ажил гүйлгээ гарсан өдрийн Монгол банкны ханшаар тайлагнана.
- гадаад валютаарх бодит үнэ цэнээр хэмжигдсэн мөнгөн бус зүйлсийг уг бодит үнэ цэнийг тодорхойлж байсан өдрийн Монгол банкны ханшаар тайлагнана.

Мөнгөн зүйлсийн төлбөр тооцоо болон мөнгөн зүйлсийг тайлант үе эсвэл өмнөх санхүүгийн тайланд анх хүлээн зөвшөөрөхдөө хөрвүүлж байсан ханшнаас өөр ялгаатай ханшаар хөрвүүлснээс үүссэн ханшийн зөрүүг тухайн үеийн ашиг алдагдалд хүлээн зөвшөөрнө.

Мөнгөн зүйлс нь гадаад валютаарх ажил гүйлгээнээс үүссэн бөгөөд уг ажил гүйлгээ гарсан өдөр ба барагдуулалтын өдрийн ханш өөрчлөгдсөн үед ханшийн зөрүү үүсдэг.

Ажил гүйлгээ гарсан болон төлбөр барагдуулсан хугацаа нь нягтлан бодох бүртгэлийн нэг ижил үед хамаарч байвал ханшийн бүх зөрүүг тухайн тайлант үед хийвэл төлбөр хийх хүртэлх тайлант үе бүрд хүлээн зөвшөөрсөн ханшийн зөрүүг тайлант үе бүрийн валютын ханшийн өөрчлөлтөөр тодорхойлно.

Мөнгөн бус зүйлсийн олз, гарзыг компани бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрсөн бол тухайн хөрвүүлэлтээс үүссэн олз, гарзыг мөн бусад дэлгэрэнгүй орлогын хэсэгт хүлээн зөвшөөрнө.

Дансны болон бусад авлага

Бэлэн мөнгө хүлээн авах гэрээт эрх үүсэх буюу өөр нэг аж ахуйн нэгжээс санхүүгийн хөрөнгийг авах эрх үүссэн тохиолдолд худалдааны болон бусад авлагуудыг анх өртгөөр нь бүртгэдэг. Дараа үеүдэд худалдааны болон бусад авлага нь найдваргүй авлагын нөөцийг хассан цэвэр боломжит үнэ цэнээрээ тусгагддаг.

Гадаад валютаар илэрхийлэгдсэн авлагыг тайлант хугацааны эцэст Монгол банкнаас зарласан албан ханшаар төгрөгт хөрвүүлэн төгрөг, гадаад валютаар давхар бүртгэнэ. Урт хугацаат авлагын бичгийг өнөөгийн үнэ цэнээр бүртгэнэ.

Дансны авлага				/төгрөг/
№	Үзүүлэлт	Дансны авлага	Найдваргүй авлагын хасагдуулга	Дансны авлага (цэвэр дүнгээр)
1	Эхний үлдэгдэл	240,403,801.95		240,403,801.95
2	Нэмэгдсэн			36,753,315.06
3	Хасагдсан (-):			685,920.00
	-Төлөгдсөн			
	- Найдваргүй болсон			
4	Эцсийн үлдэгдэл	240,403,801.95		276,471,197.01

Татвар, нийгмийн даатгалын шимтгэл (НДШ) - ийн авлага /төгрөг/

№	Төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ААНОАТ-ын авлага		
2	НӨАТ-ын авлага		
3	ХХОАТ-ийн авлага		
4	НДШ –ийн авлага		
	Нийт дүн		

Бусад богино хугацаат авлага (төрлөөр нь ангилна) /төгрөг/

№	Төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Холбоотой талаас авах авлага (эргэлтийн хөрөнгөнд хамаарах дүн)		
2	Ажиллагчдаас авах авлага		
3	Бусад талуудаас авах авлага		
	Нийт дүн		

Бараа материал

Бараа материалыг бүртгэх байнгын болон цаг үеийн 2 системээс байнгын системийг хэрэглэнэ.

Байнгын систем – Бараа материалын орлого зарлагыг хөдөлгөөн гарсан тухай бүрд нь бүртгэх ажиллагаа юм.

Бараа материалыг эзэмших эрх байгууллагад шилжсэн тухайн мөчид бараа материалын худалдан авалтыг бүртгэнэ. Бараа материалыг ашигласан, ашиглахаар тавьж олгосон, эсвэл худалдан авагчаас төлбөрөө хүлээн авсан үед бараа материалын зарлага болон борлуулалтыг бүртгэнэ.

Бараа материалыг борлуулсан үед бараа материалын дансны өртгийг холбогдох орлогыг хүлээн зөвшөөрсөн тайлант үед нь өртгөөр хүлээн зөвшөөрч бүртгэж байна.

/төгсөгч/

№	Материалын төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Түүхий эд материал		
2	Бэлэн бүтээгдэхүүн		
3	Дуусаагүй үйлдвэрлэл		
4	Бусад		
5	Хангамжийн материал		
	Нийт дүн		

Урьдчилж төлсөн зардал/тооцоо

/төгсөгч/

№	Төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Урьдчилж төлсөн зардал		
2	Бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн урьдчилгаа төлбөр		
	Нийт дүн		

Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийг түүний өртгөөс хуримтлагдсан элэгдэл болон хуримтлагдсан үнэ цэнийн бууралтыг хассан цэвэр дүнгээр тайлагнадаг ба үндсэн хөрөнгийн өртөг нь худалдан авалтын өртөг болон хөрөнгийг ашиглалтын хэвийн нөхцөлд оруулахад шууд хамаарах зардлаас бүрддэг.

Хөрөнгө тус бүрийн өртгийг үлдэх өртөг хүртэл нь ойролцоолон тооцоолсон дараах ашиглалтын хугацааны туршид, шулуун шугамын аргаар элэгдүүлнэ. Үндсэн хөрөнгийн элэгдлийг тухайн хөрөнгийг ашиглах боломжтой болсон үеэс эхэлж байгуулдаг. Хөрөнгийн элэгдэл байгуулах арга, ашиглахаар тооцсон хугацаа болон үлдэх өртгийг жил бүрийн эцэст дахин хянаж, шаардлагатай тохиолдолд тохируулга хийдэг.

Үндсэн хөрөнгийг худалдан борлуулах эсвэл хүлээгдэж буй эдийн засгийн хувьд ирээдүйд үр өгөөжгүй болсон үед нь данснаас хасдаг. Үндсэн хөрөнгийн данснаас хассаны олз эсвэл гарзыг (үндсэн хөрөнгийн дансны үнэ болон данснаас хассаны цэвэр орлогын зөрүүгээр тооцсон) тухайн жилийн дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрдөг. Компани үүсгэн байгуулагдаад удаагүй учир хөрөнгийн ашиглалт сайн, үнэ цэнийн бууралт гараагүй байна. Элэгдлийг татварын зорилгоор элэгдүүлж байгаа нь НББОУС зөрчиж байна гэж үзэж зөвлөмж хүргүүлсэн.

/төрөл/

№	Үзүүлэлт	Барилга, байгууламж	Машин, тоног төхөөрөмж	Тээврийн хэрэгсэл	Тавилга эд хогшил, Компьютер, бусад хэрэгсэл	Бусад үндсэн хөрөнгө	Нийт дүн
1		ҮНДСЭН ХӨРӨНГӨ					
1.1	Эхний үлдэгдэл	1,788,686,486.61			247,784,534.55	131,369,808.64	2,167,840,529.80
1.2	Нэмэгдсэн дүн Өөрөө үйлдвэрлэсэн Худалдаж авсан				4,237,545.5	6,773,130.00	11,010,675.45
1.3	Хасагдсан дүн (-)				4,237,545.5	6,773,130.00	11,010,675.45
1.6	Эцсийн үлдэгдэл	1,788,686,486.61			252,022,080.00	138,142,938.64	2,178,851,205.25
2		ХУРИМТЛАГДСАН ЭЛЭГДЭЛ					
2.1	Эхний үлдэгдэл	-511,642,592.58			-131,968,764.78		-638,611,357.36
2.2	Нэмэгдсэн дүн Байгуулсан элэгдэл	-44,717,154.66					-44,717,154.66
2.3	Хасагдсан дүн						
2.4	Эцсийн үлдэгдэл	-596,359,747.24			-131,968,764.78		-,328,512.02

Компани нь дараа үеийн зардлаас эдийн засгийн ирээдүйн үр өгөөжийг хүртэх магадлалтай бөгөөд тухайн зардлыг өртгийг үнэн зөв хэмжих боломжтой болсон үед үндсэн хөрөнгийн дансны үнэ дээр нэмэгдүүлэх буюу эсвэл тусдаа хөрөнгөөр хүлээн зөвшөөрч бүртгэдэг. Урсгал засварын зардал гэх мэт бусад зардлуудыг хүлээн зөвшөөрдөг.

Дансны өглөг болон бусад төлбөр

Худалдааны болон бусад өглөгүүдийг өртгөөр нь хэмждэг. Бэлэн мөнгө өгөх гэрээт эрх үүсэх буюу өөр аж ахуйн нэгжид санхүүгийн хөрөнгийг хүргэх эрх үүссэн тохиолдолд өглөгийг хүлээн зөвшөөрнө. Гэрээнд заасан үүрэг биелэгдсэн, цуцлагдсан буюу хугацаа дууссанаар түүнийг барагдуулсан тохиолдолд компани нь санхүүгийн өр төлбөрийг балансас хасдаг. Үл хүлээн зөвшөөрөгдсөн өр төлбөрийн

дансны үнэ болон барагдуулсан буюу барагдуулах өр төлбөрийн дүнгийн хоорондын зөрүүг тайлант хугацааны дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрдөг.

Дансны өглөг

/ төгрөг/

№	Ангилал	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Төлөгдөх хугацаандаа байгаа	450,850,249.81	452,200,249.81
2	Хугацаа хэтэрсэн		
3	Нийт дансны өглөгийн дүн	450,850,249.81	452,200,249.81

Татвар, НДШ-ийн өр төлбөр

/төгрөг/

№	Ангилал	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ААНОАТ өр		2,445,517.13
2	НӨАТ-ын өр	9,424,442.78	543,028.74
3	ХХОАТ-ын өр	2,098,546.57	3,278,388.60
4	Суутган тооцсон татвар	45,000.00	585,000.00
5	ҮХЭХАТ, газрын төлбөр	12,220,371.48	
6	Бусад татварын өр	333,270.00	407,790.00
	Нийт татварын дүн	24,121,630.83	7,259,724.47

Татварын зардал

Татварын зардал нь тайлант жилийн болон хойшлуулсан татварын зардлын нийлбэрээс бүрдэх бөгөөд орлогын тайланд тусгагддаг. Компанийн татвар нь тайлант жилийн татвар ногдуулах орлогод ногдох балансын өдрөөр хүчинтэй байгаа татварын хувь хэмжээгээр тооцсон бөгөөд өмнөх үеийн татварын өглөг, хойшлуулсан татвар хөрөнгө ба өр төлбөрийг тохируулсан хүлээгдэж буй татварын хөрөнгө эсвэл өглөг юм.

Нийгмийн даатгалын шимтгэл

Монгол улсын Нийгмийн даатгалын тухай хуулийн дагуу бүтэн цагаар ажиллагчдын цалингаас шитгэл суутгах ба гэрээт ажилчид нь ажилчдын адилаар нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг суутгуулах бөгөөд ажил олгогчоос хуульд заасан хэмжээгээр тооцоолон холбогдох байгууллагад төлдөг. Компани НДШ-ийг тухай бүр төлж хэвшсэн өр төлбөргүй байна.

Нэмэгдсэн өртгийн албан татвар

Монгол улсын Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулиар нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ) ноогдох бараа, ажил үйлчилгээний орлогод 10 хувиар тооцож НӨАТ төлдөг.

Зээлийн өр төлбөр

/ төгрөг/

№	Төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
	Богино хугацаат зээл		
	Урт хугацаат зээл		
	Нийт зээлийн дүн		
	Үүнээс холбоотой талд өгөх өглөг		

Компанийн гаргасан санхүүгийн өр төлбөр болон өмчийн хэрэгслүүд нь гэрээт ажлын мөн чанар болон санхүүгийн өр төлбөр, өмчийн хэрэгслийн тодорхойлолтын дагуу ангилагддаг. Өмчийн хэрэгсэл гэдэг нь бүх өр төлбөрийг хассаны дараа компанийн хөрөнгөнд үлдэх хувь оролцоог нотолсон аливаа гэрээ юм.

Орлого хүлээн зөвшөөрөлт

Эдийн засгийн ирээдүйн үр өгөөжийн найдвартай хэмжих боломжтой өсөлт нь хөрөнгийн нэмэгдүүлж эсвэл өр төлбөрийг багасгаж байвал орлогын тайланд орлогоор хүлээн зөвшөөрнө. Өөрөөр хэлбэл орлогыг хүлээн зөвшөөрөхийн хамтаар хөрөнгийн өсөлт болон өр төлбөрийн бууралтыг нэг зэрэг хүлээн зөвшөөрнө гэсэн үг юм (Жишээлбэл, бараа борлуулж, ажил үйлчилгээ үзүүлсэн үед хөрөнгийг нэмэгдүүлэх, эсвэл зээлдүүлэгчийн өрийг барагдуулснаар өр төлбөрийг багасгах гэх мэт). / төгрөг/

№	Орлогын нэр төрөл	2023 он	2024 он
1	Түрээсийн орлого	215,230,596.33	412,233,590.88
2			
5	Бусад орлого		
	ДҮН	215,230,596.33	412,233,590.88

Зардал хүлээн зөвшөөрөлт

Эдийн засгийн ирээдүйн үр өгөөжийн найдвартай хэмжих боломжтой бууралт нь хөрөнгийг багасгах эсвэл өр төлбөрийг нэмэгдүүлэхээр байвал орлогын тайланд зардлыг хүлээн зөвшөөрнө. Өөрөөр хэлбэл зардлыг хүлээн зөвшөөрөхийн хамтаар хөрөнгийн бууралт болон өр төлбөрийн өсөлтийг хүлээн зөвшөөрнө гэсэн үг юм (Жишээлбэл, ажилтнуудын цалин хөлсийг хуримтлуулах, тоног төхөөрөмжийн элэгдэл гэх мэт).

Гарсан зардал болон олсон орлогын хоорондох шууд хамаарлыг үндэслэн орлогын тайланд зардлыг хүлээн зөвшөөрнө.

Эзэмшигчдийн өмч

Гаргасан энгийн хувьцааг эзэмшигчдийн өмч гэж ангилна. Шинэ хувьцааг гаргахтай шууд холбогдон гарсан өсөн нэмэгдэх зардлыг татварын нөлөөллийг хассан дүнгээр эзэмшигчдийн өмчийн сөрөг тохируулах дансаар тусгана. Хүлээн авч үзэж байгаа зах зээлийн үнэ нь гаргасан хувьцааны нэрлэсэн үнэтэй тэнцүү байна.

Санхүүгийн хэрэгслүүд

Санхүүгийн хөрөнгө болон өр төлбөр нь мөнгө, түүнтэй адилтгах зүйлс, толгой компанид өгөх өглөг зэргээс бүрддэг.

Санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийг компани уг хэрэгсэлтэй холбоотой гэрээний нэг тал болсон үед санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрдөг. Санхүүгийн

хөрөнгө болон өр төлбөрийг анхлан зах зээлийн үнээр нь бүртгэдэг. Санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийг худалдан авах эсвэл түүнийг гаргахтай холбогдон гарсан шууд зардлыг анхны хүлээн зөвшөөрөлтийн үед санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн зах зээлийн үнэ дээр нэмж, эсвэл түүнээс хасаж бүртгэдэг.

Олгосон зээл болон авлага

Зээл болон авлага нь идэвхтэй зах зээлд арилжаалагддаггүй тогтмол эсвэл тодорхой төлбөр бүхий үүсмэл бус санхүүгийн хөрөнгө юм. Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараах үеүдэд санхүүгийн байдлын тайлангийн өдрүүдээр зээл болон авлагыг үр ашигт хүүгийн аргаар хорогдуулсан өртгөөс аливаа тодорхойлсон үнэ цэнийн бууралтаас үүссэн гарзыг хассан дүнгээр илэрхийлдэг.

Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Тайлант хугацааны эцэст санхүүгийн хөрөнгөнд үнэ цэнийн бууралт үүссэн эсэхийг үнэлдэг. Санхүүгийн тайланд анх бүртгэгдсэнээс хойш санхүүгийн ирээдүйн тооцоолсон мөнгөн урсгалд нөлөөлөх нэг буюу түүнээс дээш тохиолдол гарсан бодит нотолгоо байгаа үед санхүүгийн хөрөнгийн үнэ цэнэ буурдаг.

Үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо нь дараах зүйлсээс бүрдэнэ. Үүнд:

- Хувьцаа гаргагч болон харилцагч тал нь томоохон санхүүгийн хүндрэлд орох; эсвэл
- Үндсэн төлбөр болон хүүгийн хувьд хууль зөрчих, төлбөр гүйцэтгэх чадваргүй болох; эсвэл
- Зээлдэгч нь татан буугдах эсвэл санхүүгийн дахин зохион байгуулалтад орох магадлал болох зэрэг болно.

Хөрөнгийн үнэ цэнэ буурах нь бодитоор нотлогдсон үед үнэ цэнийн бууралтын гарзыг дэлгэрэнгүй орлогын тайланд хөрөнгийн дансны үнэ болон анхны үр ашигт хүүгийн түвшнээр дискаунтчилан тооцоолсон ирээдүйн мөнгөний өнөөгийн үнэ цэнийн зөрүүгээр бүртгэдэг.

Санхүүгийн өр төлбөр ба өмч

Өмчийн хэрэгсэл гэдэг нь бүх өр төлбөрийг хассаны дараа компанийн хөрөнгөнд үлдэх хувь оролцоог нотолсон аливаа гэрээ юм.

Үл хүлээн зөвшөөрөлт

Компанийн хөрөнгөөс мөнгөн урсгал хүлээн авах эрх дуусгавар болсон эсвэл санхүүгийн хөрөнгүүдийг шилжүүлсэн, мөн компани нь санхүүгийн хөрөнгүүдийн эзэмшлээс үүдэх эрсдэл болон өгөөжийг үндсэнд нь шилжүүлсэн бол санхүүгийн хэрэгслүүдийг үл хүлээн зөвшөөрдөг. Үл хүлээн зөвшөөрөлтөөр нөгөө талд шилжүүлсэн хөрөнгийн дансны үнэ ба хүлээн авсан буюу авах орлого, эзэмшигчийн өмчид шууд хүлээн зөвшөөрсөн олз эсвэл гарзын нийлбэр дүнгийн хоорондын зөрүүг дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрдөг.

Санхүүгийн хэрэглүүр

Санхүүгийн эрсдэлийн удирдлагын зорилго, бодлого

Компанийн санхүүгийн үндсэн хэрэгслүүд нь мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө, өр төлбөр (толгой компанид өгөх өглөг) зэргээс бүрдэж байна. Удирдлага нь тохиромжит арга хэмжээг цаг тухайд нь болон үр дүнтэй байдлаар хэрэгжүүлж буй гэдгийг хангахын тулд эдгээр эрсдэлийг удирдан хянадаг

Капиталын эрсдэлийн удирдлага

Компани нь өр болон өмчийн үлдэгдлийн оновчтой зохицлыг бий болгох замаар хувь эзэмшигчдэд өгөх өгөөжийг хамгийн өндөр түвшинд байлгах зуур компанийн тасралтгүй үйл ажиллагааг хангах зорилгоор капиталаа удирддаг.

Компанийн капиталын бүтэц нь толгой компанид төлөх мөнгөн дүнг агуулсан өр төлбөр, мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө, гаргасан хувьцаат капитал, капитал нөөц болон хуримтлагдсан алдагдал зэрэг компанийн өмчийн эздэд хамаарах өмчөөс бүрдэж байна.

Компанийн удирдлага капиталын бүтцийг тогтмол хянадаг. Энэхүү хяналтын хүрээнд удирдлага нь капиталын өртөг болон капиталын ангилал тус бүрд хамаарах эрсдэлийг тооцож үздэг. Компани нь ногдол ашгийн төлбөр, шинэ өр гаргалт эсвэл одоогийн өрийг барагдуулах мөн шинэ хувьцаа гаргах зэрэг замаар ерөнхий капиталын бүтцээ тэнцвэржүүлж болно.

Болзошгүй өр төлбөр

Болзошгүй өр төлбөр нь компанийн өнгөрсөн үйл явдлын үр дүнд гарах боломжтой үүрэг хариуцлага бөгөөд түүний орших байдал нь компанийн бүрэн хяналтад ороогүй, зөвхөн ирээдүйн нэг буюу хэд хэдэн үйл явдлын тохиолдолд, эс тохиолдлоор батлагдах одоогийн үүрэг хариуцлага юм.

Болзошгүй өр төлбөрийг санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрдөггүй ба харин тодруулгын хэсэгт оруулдаг бөгөөд энэхүү санхүүгийн тайлангийн тодруулгад болзошгүй өр төлбөрийн талаарх тодруулга байхгүй болно.

Тайлагналын өдрийн дараах үйл явдал

Санхүүгийн тайлангийн өдөр болон аудитын тайланг бэлтгэсэн өдрийн хооронд тохиолдсон болон үйл ажиллагаанд нөлөөлөх томоохон өөрчлөлт, үйл явдал гараагүй болно.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

"МИШЭЭЛ-ОД АУДИТ" ХХК-ИЙН ЗАХИРАЛ
АУДИТЫН БАГИЙН АХЛАГЧ

ЧАНАРЫН ХЯНАЛТЫН МЕНЕЖЕР



Т.ОДОНЧИМЭГ



Э.ЭНХЦЭЦЭГ

БЭЛТГЭСЭН:

"МИШЭЭЛ-ОД АУДИТ" ХХК-ИЙН АУДИТОР



М.ЦЭНД-АЮУШ

2025 оны 02 дүгээр сар 25